



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 24 өдөр

Дугаар А/676

Хэрлэн сум

Бүтээн байгуулалтын ажлын зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 66.3 дахь хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх заалт, 35.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд бүтээн байгуулалтын ажлуудыг төлөвлөх, хэрэгжилтийн үр дүнг сайжруулах, зохион байгуулах, хяналт тавихад төрийн байгууллагуудын уялдаа холбоог хангах замаар үндэслэлтэй, шуурхай шийдвэр гаргах, зорилго бүхий “Бүтээн байгуулалтын ажлын зөвлөл”-ийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Нарийн бичгийн
дарга:

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын
хэлтсийн дарга

Гишүүд:

Аймгийн Засаг даргын орлогч

Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын захирагч
Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын
Дарга

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын
дарга Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга

Аймгийн ерөнхий архитектор

Худалдан авах ажиллагааны газрын дарга

Орон нутгийн өмчийн газрын дарга

Хэнтий цахилгаан түгээх сүлжээ салбарын Захирал

“Харгуй” ТӨХК -ийн гүйцэтгэх захирал

“Хэнтий-Ус” ХХК-ийн гүйцэтгэх захирал


Мэдээлэл холбооны сүлжээ ТӨК-ий Хэнтий аймаг дахь
газрын ерөнхий инженер

2.

2.Бүтээн байгуулалтын ажлын зөвлөлийн ажиллах журмыг хавсралтаар баталсугай.


3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны А/241 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



ДАЮУРБУНЬ

12 дугаар сарын 29-ний өдрийн
4/1676 дугаар захирамжийн хавсралт



БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Аймгийн хэмжээнд бүтээн байгуулалтын ажлуудыг төлөвлөх, хэрэгжилтийн үр дүнг сайжруулах, зохион байгуулах, хяналт тавихад төрийн байгууллагуудын уялдаа холбоог хангах замаар үндэслэлтэй, шуурхай шийдвэр гаргахад энэхүү журмын зорилго оршино.

Хоёр. Зөвлөлийн үйл ажиллагаа

2.1. Зөвлөлийн дарга нь аймгийн Засаг дарга байна.

2.2. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байна.

2.3. Хурлаар бүтээн байгуулалтын ажлуудын төлөвлөлт, хэрэгжилтийн явц болон тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, үр дүнг сайжруулах, зохион байгуулах, хяналт тавих, харилцан мэдээлэл солилцох, дэд бүтцийн холбогдолтой бусад асуудлыг хэлэлцэнэ.

2.4. Хурлын үйл ажиллагааны бэлтгэлийг зөвлөлийн нарийн бичгийн дарга хангах бөгөөд хуралдааныг зөвлөлийн дарга удирдан явуулна.

2.5. Зөвлөлийн гишүүд хэлэлцэх асуудалтай нарийн танилцаж, санал дүгнэлт гарган хуралдаанд идэвхтэй оролцох үүрэгтэй.

2.6. Зөвлөлийн гишүүд хуралд оролцох боломжгүй тохиолдолд зөвлөлийн нарийн бичгийн даргад урьдчилан мэдэгдэх үүрэгтэй бөгөөд өөрийн албан үүргийг орлох албан тушаалтныг оролцуулна.

2.7. Зөвлөлийн дарга хэлэлцэх асуудлын онцлог, хамрах хүрээг харгалзан зөвлөлийн гишүүдээс гадна төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжийн удирдлага, холбогдох албан хаагчийг оролцуулан өргөтгөсөн хэлбэрээр хурлыг хуралдуулж болно.

Гурав. Зөвлөлийн хурлын тэмдэглэл

3.1. Зөвлөлийн хурлаас тэмдэглэл гарах бөгөөд тэмдэглэлийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн хөтөлж, тэмдэглэлд тусгагдсан асуудлыг холбогдох албан тушаалтан, байгууллага, иргэдэд хүргүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих ажлыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс хариуцна.

3.2. Тэмдэглэлд тухайн өдрийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлын жагсаалт, зөвлөлийн гишүүдийн ирцийн байдал, хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой холбогдон гарсан асуулт, хариулт, санал дүгнэлт, эцсийн шийдвэрийг тодорхой бичнэ.